

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

АЙМГУУДЫН ЗДТГ

2017 ОНЫ 5 ДУГААР САРД

2017 оны 5 дугаар сард Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгуудын Засаг даргын тамгын газар (ЗДТГ)-ууд 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 100 хувь ил тод болгожээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу нийтэд ил тод болгох ёстой мэдээллүүдээс зургаан төрлийн мэдээллийг сонгон авч 21 аймгийн ЗДТГ-ууд хэрхэн ил тод мэдээлж байгаад орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд сар бүр ажиглалт хийж байна.

АЖИГЛАЛТЫН ЕРӨНХИЙ ҮР ДҮН



Өмнөх сард 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллээ 8 аймгийн ЗДТГ бүрэн мэдээлж байсан бол 5 дугаар сард 5 болж буурчээ.

Шилэн дансны тухай хуулийн дагуу аймгуудын ЗДТГ-ын 2017 оны 5 дугаар сард ил тод болгосон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, гүйлгээний мэдээллийг Сангийн яамны Төрийн сангийн тухайн сарын дансны хуулгатай харьцуулж үзэв (Тайлбар 2-ыг үзнэ үү).

100.0% Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ

75.0% Дорнод

71.4% Говь-Алтай

66.7% Дорноговь, Дундговь

42.9% Завхан, Хэнтий

50.0% Архангай, Баянхонгор, Өмнөговь

40.0% Төв

33.3% Говьсүмбэр, Өвөрхангай

27.3% Сүхбаатар

16.7% Хөвсгөл

0.0% Увс, Ховд

Тайлбар: 1 = 10%

АЙМГУУДЫН ЗДТГ-ЫН НИЙТЭЛСЭН ГҮЙЛГЭЭ БА ТҮҮНД ХАМААРАХ ШИЙДВЭРҮҮД



(Тайлбар 1-ийг үзнэ үү)

ХУДАЛДАН АВАЛТ БА ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- 2017 оны 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг Баян-Өлгий аймгаас бусад аймгийн ЗДТГ хуулийн хугацаанд нь буюу 6 дугаар сарын 8-ны дотор ил тод болгожээ.
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.4-р заалтын дагуу 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг 6 аймаг (Баян-Өлгий, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий)-ийн ЗДТГ нийтэлжээ. Мэдээлэл нийтлээгүй зарим ЗДТГ "тухайн сард 5 саяас дээш төгрөгийн худалдан авалт хийгдээгүй" гэсэн тайлбар өгчээ.
- Хуулийн дагуу 1 дүгээр сарын 10-ны дотор нийтэд ил тод болгох ёстой тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг таван аймгийн ЗДТГ хугацаанд нь, гурван аймгийн ЗДТГ 2, 3 дугаар саруудад тус тус нийтэлсэн байна. Харин үлдсэн аймгуудын ЗДТГ 5 дугаар сарын байдлаар уг төлөвлөгөөг ил тод болгоогүй хэвээр байна.

Дүн мэдээнд хамаарах тайлбар:

- Цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээний тоог гаргахдаа шилэн дансанд ЗДТГ-ын тухайн сард нийтэлсэн нийт гүйлгээний тоог тоолж гаргасан болно.
- Төрийн сангийн гүйлгээнээс ил тод болгосон хувийг үнэлэхдээ зөвхөн энэ оны 5 дугаар сард хамаарах 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт болон гүйлгээг тооцсон болно. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий залруулга хийсэн гүйлгээг тоонд оруулсан болно.

АШИГЛАСАН МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудас
- ЗДТГ-ын цахим хуудас
- ЗДТГ-ын мэдээллийн самбар
- Төрийн сангийн дансны хуулга

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн мониторингийн дүнг сар бүр мэдээлж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг www.forum.mn цахим хуудаснаас үзнэ үү.